



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/259/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
https://audit.mn/?page_id=579
Мөрөн хот

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Ихэрмөрөн-аудит ХХК-ийн
Захирал: Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Чанарын хяналтын менежер: Д.Оюундаваа
Утас: 96199692 Цахим хаяг: oyundavaa9692@gmail.com
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.....	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.18 № 01/81
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨГЖИМТ
ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАНЗРАГЧ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	310,716,605.90	325,355,894.10
33	АВЛАГА	500,000.00	606,206.65
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	604,076.65
33300	Татаас, санхүүжилтийн авлага	500,000.00	2,130.00
35	БАРАА МАТЕРИАЛ	310,216,605.90	324,749,687.45
354	Хангамжийн материал	310,216,605.90	324,749,687.45
35410	Бичиг хэргийн материал	767,150.00	00.00
35420	Аж ахуйн материал	1,687,500.00	971,000.00
35440	Түлш, шатах тослох материал	245,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	307,516,955.90	323,778,687.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,000,056,319.30	496,436,935.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,000,056,319.30	496,436,935.82
392	Биет хөрөнгө	395,687,784.34	389,600,068.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,329,375,512.54	1,329,375,512.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,072,232,425.01	-1,095,183,827.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,900,000.00	34,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,271,875.03	-7,634,375.07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,453,040.08	98,364,562.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,236,569.48	-13,522,163.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,811,150.01	36,964,550.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,390,824.20	-32,454,772.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	264,260,840.00	255,683,540.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-199,514,064.57	-216,892,958.49
393	Биет бус хөрөнгө	604,368,534.96	106,836,867.44
39301	Програм хангамж	5,473,070.00	2,839,670.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,324,535.04	-222,802.56
39303	Бусад биет бус хөрөнгө	604,220,000.00	104,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,310,772,925.20	821,792,829.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,310,772,925.20	821,792,829.92
51	Засгийн газрын хувь оролцоо	1,310,772,925.20	821,792,829.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,129,565,915.31	629,565,915.31
51101	Өмч: - төрийн	1,129,565,915.31	629,565,915.31
512	Хуримтлагдсан үр дүн	-105,400,209.05	-93,692,904.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-105,400,209.05	-104,712,809.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	11,019,904.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	286,607,218.94	285,919,818.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,310,772,925.20	821,792,829.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	981,912,646.70	1,008,889,256.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,020,746.70	74,096,756.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,020,746.70	70,946,766.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,020,746.70	70,946,766.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,020,746.70	70,946,766.00
122	Тусламжийн орлого	00.00	3,149,990.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	3,149,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	942,891,900.00	934,792,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,507,000.00	8,964,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	200,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,188,000.00	6,934,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,519,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	800,000.00	1,830,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	934,384,900.00	925,828,000.00

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	934,384,900.00	925,828,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	992,427,141.90	995,336,351.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	992,427,141.90	995,336,351.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,496,706.12	936,932,394.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,392,861.00	592,514,648.20
210101	Үндсэн цалин	622,392,861.00	473,423,395.45
210102	Нэмэгдэл	00.00	119,091,252.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,251,524.12	77,958,982.75
210201	Тэтгэврийн даатгал	53,478,798.12	54,176,057.02
210202	Тэтгэмжийн даатгал	6,286,929.00	6,014,915.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,985,862.00	4,761,532.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,216,930.00	1,181,202.90
210205	Эрүүл мэндийн даатгал	12,283,005.00	11,825,274.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,881,879.28	173,129,463.08
210301	Гэрэл, цахилгаан	3,183,464.18	2,159,460.60
210302	Түлш, халаалт	167,342,005.60	167,342,070.48
210303	Цэвэр, бохир ус	1,356,409.50	3,627,932.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,296,350.42	17,804,361.34
210401	Бичиг хэрэг	455,950.00	1,152,350.00
210402	Тээвэр, шатахуун	2,346,100.54	3,439,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	525,799.88	1,619,662.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	108,000.00	177,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	860,500.00	872,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	10,543,948.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,986,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,986,000.00
2107	Томилолт, зочны зардал	298,800.00	754,000.00
210702	Дотоод албан томилолт	298,800.00	754,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,207,898.93	7,573,510.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,515,288.93	5,496,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	40,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,010.00	437,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	495,000.00
210807	Газрын төлбөр	313,100.00	312,010.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,167,392.37	65,211,429.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	137,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,167,392.37	65,073,529.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,930,435.78	58,403,956.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,762,800.00	57,165,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,824,800.00	51,725,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,938,000.00	5,440,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,167,635.78	1,238,156.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,167,635.78	1,238,156.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,514,495.20	13,552,904.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,533,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	2,533,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,533,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-10,514,495.20	11,019,904.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,129,565,915.31	288,586,273.41	-96,864,768.32	1,321,287,420.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,979,054.47	1,979,054.47

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,129,565,915.31	288,586,273.41	-94,885,713.85	1,323,266,474.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-1,979,054.47	00.00	-1,979,054.47
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,514,495.20	-10,514,495.20
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,129,565,915.31	286,607,218.94	-105,400,209.05	1,310,772,925.20
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,129,565,915.31	286,607,218.94	-105,400,209.05	1,310,772,925.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	687,400.00	687,400.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,129,565,915.31	286,607,218.94	-104,712,809.05	1,311,460,325.20
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-687,400.00	00.00	-687,400.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-500,000,000.00	00.00	00.00	-500,000,000.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,019,904.72	11,019,904.72
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	629,565,915.31	285,919,818.94	-93,692,904.33	821,792,829.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	942,891,900.00	935,292,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	942,891,900.00	935,292,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,507,000.00	9,464,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	200,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,188,000.00	6,934,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,519,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	800,000.00	2,330,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	934,384,900.00	925,828,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	934,384,900.00	925,828,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	942,891,900.00	930,452,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,891,900.00	930,452,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	917,461,464.22	872,046,413.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,392,862.65	593,118,712.68
210101	Үндсэн цалин	479,820,100.00	468,288,108.35
210102	Нэмэгдэл	142,572,762.65	124,830,604.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,241,922.97	77,958,994.92
210201	Тэтгэврийн даатгал	55,234,558.86	54,171,869.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,779,280.18	6,019,115.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,609,983.93	4,761,532.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,147,100.00	1,181,202.90
210205	Эрүүл мэндийн даатгал	11,471,000.00	11,825,274.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,306,573.68	173,129,463.08
210301	Гэрэл, цахилгаан	3,183,464.18	2,159,460.60
210302	Түлш, халаалт	194,766,700.00	167,342,070.48
210303	Цэвэр, бохир ус	1,356,409.50	3,627,932.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,115,300.42	6,740,862.89
210401	Бичиг хэрэг	883,100.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,591,100.54	3,194,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	525,799.88	1,619,662.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	108,000.00	177,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,007,300.00	750,000.00
2105	Нормативт зардал	348,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	348,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,667,600.00
210604	Урсгал засвар	00.00	2,667,600.00

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	298,800.00	754,000.00
210702	Дотоод албан томилолт	298,800.00	754,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,758,004.50	17,538,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,065,394.50	15,461,870.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	40,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,010.00	437,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	495,000.00
210807	Газрын төлбөр	313,100.00	312,010.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	137,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	137,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,430,435.78	58,406,086.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,762,800.00	57,165,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,824,800.00	51,725,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,938,000.00	5,440,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,667,635.78	1,240,286.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,667,635.78	1,238,156.43
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		2,130.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,840,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,840,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,840,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,840,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,840,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,840,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	925,828,000.00	924,589,843.57	1,238,156.43	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	925,828,000.00	924,589,843.57	1,238,156.43	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	869,102,200.00	867,904,043.57	1,198,156.43	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,466,100.00	593,118,712.68	347,387.32	99.9
210101	Үндсэн цалин	468,745,500.00	468,288,108.35	457,391.65	99.9
210102	Нэмэгдэл	124,720,600.00	124,830,604.33	-110,004.33	100.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,000,600.00	77,958,994.92	41,605.08	99.9
210201	Тэтгэврийн даатгал	54,194,600.00	54,171,869.19	22,730.81	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,021,800.00	6,019,115.51	2,684.49	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,767,100.00	4,761,532.60	5,567.40	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,182,200.00	1,181,202.90	997.10	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	11,834,900.00	11,825,274.72	9,625.28	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,374,600.00	173,129,463.08	245,136.92	99.9
210301	Гэрэл, цахилгаан	2,317,400.00	2,159,460.60	157,939.40	93.2
210302	Түлш, халаалт	167,342,100.00	167,342,070.48	29.52	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,715,100.00	3,627,932.00	87,168.00	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	6,741,100.00	6,740,862.89	237.11	100.0
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,194,200.00	3,194,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,619,900.00	1,619,662.89	237.11	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	177,000.00	177,000.00	0.00	100.0

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	750,000.00	750,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,534,500.00	1,534,500.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,534,500.00	1,534,500.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	478,000.00	22,000.00	95.6
210702	Дотоод албан томилолт	500,000.00	478,000.00	22,000.00	95.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,485,300.00	14,943,510.00	541,790.00	96.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,349,700.00	12,866,500.00	483,200.00	96.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	496,000.00	437,500.00	58,500.00	88.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	495,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	312,100.00	312,010.00	90.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,725,800.00	56,685,800.00	40,000.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,725,800.00	56,685,800.00	40,000.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,725,800.00	51,725,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	4,960,000.00	40,000.00	99.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	925,828,000.00	924,589,843.57	1,238,156.43	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	925,828,000.00	924,589,843.57	1,238,156.43	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	925,828,000.00	924,589,843.57	1,238,156.43	99.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66.00	64.00	2.00	97.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	47.00	2.00	95.9
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,464,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,464,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,982,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,133,100.00
210604	Урсгал засвар	1,133,100.00
2107	Томилолт, зочны зардал	276,000.00
210702	Дотоод албан томилолт	276,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,435,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,435,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	137,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	480,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,130.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9464500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,464,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,934,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,330,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатны хяналтыг, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нь Хөвсгөл нутгийн олон ястны ардын уламжлалт урлагийг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх, өвлүүлэх, уламжлуулах, хөдөө орон нутгийн ард иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий Хөвсгөл аймгийн Засаг даргын харьяа мэргэжлийн урлагийн байгууллага юм. Анх 1930 онд “Улаан гэр” нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, 1976 оноос хөгжимт драмын театр болон мэргэжлийн урлагийн байгууллага болсон бөгөөд энэ хугацаанд 400 гаруй өөрийн болон орчуулгын хөгжимт, драмын жүжиг, дуурь, 50 гаруй хүүхдийн жүжиг, теле концерт, 3500 гаруй хүндэтгэлийн концертоор урын сангаа бүрдүүлэн ард иргэдэд урлагийн үйлчилгээг үзүүлж байна.

“Иргэдээ сонсох” нэрлэсэн жилийн хүрээнд хөгжмийн тоглолт 1, сонгодог жүжиг 1, бүжиг 1, цахим тоглолт 2, зохиомжит контент 1, хүүхдийн нэвтрүүлэг 1, “Хүрэхүй” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн. 2021 онд “Хоймор эгшиглэн” хөгжмийн тоглолтоор өвөл цагийн нээлтээ хийсэн нь дэлхийн болон Монголын хөгжмийн зохиолчдын шилдэг бүтээлүүдээс бүрдсэн, үндэсний язгуур урлаг, этник, сонгодог бүтээлүүдийг хослуулсан орчин үеийн шинэлэг тавилттай бүтээл болсон.

“Хөх сувд” найрал хөгжмийн хамтлагийн тоглолтыг шинэчлэн найруулж тавьсан. Ардын хувьсгалын 100 жил, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойд зориулж “Начингүй наадам” теле концерт тавьж, урын санг арвижуулан олны хүртээл болгожээ. Аймаг, орон нутагт болсон цаг үеийн шинжтэй арга хэмжээнүүдэд соёлын үйлчилгээг тухай бүрт үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна. Учир нь дотоод хяналт хариуцсан ажилтан нь санхүүгийн мэдлэггүй, дотоод хяналт, аудитаар мэргэшээгүй байна.

Тус байгууллага нь Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Үзвэрийн билетийг хэвлэж орлогод авах, зарцуулалтад хяналт тавих, тооцоо бодох, орлого тушаах, тоглолтын хувцасны үйлдвэрлэл, театрын урын өв санг бүртгэлжүүлэх, хөрөнгийг театрын жижиг хэрэглэгдэхүүн, тоглолтын хувцас, тайзны хэрэгсэл, хөгжмийн зэмсэг гэх мэт ангилан бүртгэх зэрэг байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан бодлогын баримт бичиг боловсруулан баталж, мөрдөх талаар аудитаар зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант жилд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Хөгжимт драмын театрын 2019-2020 он, 2021 оны 1-2 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, 22.3 сая төгрөгийн 7 акт тогтоосноос 21.7 сая төгрөгийн 5 актын биелэлт хангагдаж, 0.6 сая төгрөгийн 2 акт биелээгүй байна. Хяналт шалгалтаар бүртгэл, тооллогоор тавих хяналтыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт өгчээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 992.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 19.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 489.0 сая төгрөгөөр буюу 37.3 хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс биет бус хөрөнгийн данс, бусад хангамжийн материал, машин, тоног төхөөрөмжийн дансанд тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.5	0.6	0.1
Бараа материал	310.2	324.7	14.5
Үндсэн хөрөнгө	1,000.1	496.4	-503.6
Нийт хөрөнгө	1,310.8	821.8	-489.0
Өр төлбөр	0.00	0.00	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,310.7	821.7	-489.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,310.7	821.7	-489.0

Авлага дансны үлдэгдэлд илүү олгосон 0.6 сая төгрөгийн цалин, нэмэлт төсвийн данснаас орон нутгийн төсөвт төвлөрүүлж, авлагаар баталгаажуулсан дүн тусгагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14.5 сая төгрөгөөр өсөхөд дараах ажил гүйлгээ нөлөөлжээ. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 18.9 төгрөг
- Үнэ төлбөргүй хүлээж авсан 14.9 сая төгрөг
- Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 8.8 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн Хөгжим драмын театрын даргын 2021 оны 07 сарын 19-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар хуучирч муудсан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 67 нэр төрлийн 204 ш 10.5 сая төгрөгийн бараа материалыг акталж, устган данснаас хассан;

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлтөд дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор шинээр театрын барилга барих зориулалттай Ирээдүй сургуулийн баруун талд байрлалтай 20,482.7 квадрат метр, 500.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий газрыг аймгийн Засаг даргын нөөцөд шилжүүлэн данснаас хассан;
- Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 05 сарын 04-ний өдрийн А/62 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 1.7 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер 1 ширхэгийг орлогод авсан;
- Юу лайк консалтинг ХХК-аас 1.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар авсан;
- Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 3.3 сая төгрөгөөр Бодь электроникс ХХК-аас 2 ширхэг зөөврийн компьютерийг орлогод авсан;
- Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 10 сарын 25-ны өдрийн А/112 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хамтын оролцоо-хариуцлагатай засаглал” дэд

- хөтөлбөрийн хүрээнд “Соёл олон ястны өв” театрын дууны тоног төхөөрөмжийг шинэчлэн 45.1 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авсан;
- Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 10 сарын 28-ны өдрийн А/113 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хамтын оролцоо-хариуцлагатай засаглал” дэд хөтөлбөрийн хүрээнд 4.0 сая төгрөгийн суурин, зөөврийн компьютер, принтер орлогод авсан;
 - Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, “0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 30 нэр төрлийн 21.6 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, өртгийг шинэчлэн 7.3 сая төгрөгөөр тогтоосон;
 - Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 21 нэр төрлийн 8.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан зэрэг болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 821.7 сая төгрөг болж, 489.0 сая төгрөгөөр буурсан нь 500.0 сая төгрөгийн суурь үнэтэй газрыг данснаас хассан болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39.0	70.9	31.9
Хандивын орлого		3.1	3.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	934.4	925.8	-8.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	8.5	9.0	0.5
Үйл ажиллагааны орлогын дүн	981.9	1,008.9	27.0
Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	700.6	670.5	-30.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171.9	173.1	1.2
Хангамж, бараа материалын зардал	4.3	17.8	13.5
Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	2.0	2.0
Томилолт, зочны зардал	0.3	0.8	0.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27.2	7.6	-19.6
Бараа үйлчилгээний бусад зардал	63.2	65.2	2.0
Урсгал шилжүүлэг	24.9	58.4	33.5
Үйл ажиллагааны зардлын дүн	992.4	995.3	2.9
Үйл ажиллагааны бус зардлын дүн		-2.5	
Нийт үр дүн	-10.5	11.0	21.5

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 1,008.9 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 2.7 хувь буюу 27.0 сая төгрөгөөр өссөн нь хандив, үнэ төлбөргүй хүлээж авсан орлогын дүн 35.1 сая төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн дүн 8.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Харин үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг 995.3 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 2.9 сая төгрөгөөр, нийт үр дүн 21.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь цалин хөлс, шимтгэлийн зардал, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, урсгал шилжүүлэг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр 2021 оны төсвийн төлөвлөлтийг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.1 заалтад заасан хугацаа буюу 7 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт 2020 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 69 дүгээр тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2021 оны төсвийг 1,029.8 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн байх бөгөөд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 977.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар нэг удаа зохицуулалт хийж, тус байгууллагын төсвийг 51.3 сая төгрөгөөр бууруулснаар төсвийн зарлага 925.8 сая төгрөг болжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны төсвийн гүйцэтгэлийг 924.6 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 925.8 сая төгрөгтэй харьцуулахад 99.8 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 1.2 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 7.7 заалтад заасны дагуу Хөвсгөл аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд анхны батлагдсан төсөвтэй харьцуулахад 52.6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны төсвийн жилд Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нэмэлт төсвийн дансаар дараах 9.5 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/336 дугаар захирамжаар уран бүтээлчдийн хувцас, хэрэглэл шинэчлэх зориулалттай 6.6 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/503 дугаар захирамжаар намрын ногоон өдрүүд арга хэмжээний зардалд 0.3 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/43 дугаар захирамжаар 2020 оны жилийн эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 0.5 сая төгрөгийг буцааж олгосон
- Байгууллагын үйл ажиллагааг дэмжиж Мобиком ХХК-аас 0.2 сая төгрөгийн хандивын орлого

- Хоймор эгшиглэн тоглолтын орлого 1.8 сая төгрөг

Тоглолтын орлогоос орсон 1.8 сая төгрөгийг эх үүсвэр дутагдаж байгаа үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж, бусад орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагад бүртгэлтэй байсан 500.0 сая төгрөгийн үнэлгээтэй газрыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолыг үндэслэн данснаас хассаныг анхаарал хандуулах гол асуудал гэж үзлээ.

Тус театрын барилга нь 1966 онд ашиглалтад орсон, 50 гаруй жил ашиглагдаж байгаа хуучин барилга бөгөөд 2013 онд театрын зориулалтаар үйл ажиллагаа явуулах боломжгүй талаарх мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2013 оны 03-р сарын 12-ны өдрийн 23-03-015/139 тоот дүгнэлт гарч, улмаар 2018 онд тоглолтын үеэр таазнаас том шавар нурж хүүхдийн гар гэмтээсэн тул олон нийтийн арга хэмжээ явуулахыг зогсоосон байна.

Театрын шинэ барилга бариулахаар орон нутгийн төсвөөр зураг, төсөв 124.8 сая төгрөгөөр хийлгэсэн нь театрын хөрөнгөнд бүртгэлтэй боловч асуудал шийдэгдээгүй байгаа нь орон нутгийн иргэдэд урлаг, соёлын үйлчилгээ үзүүлэх, ажиллагсад аюулгүй орчинд ажиллахад хүндрэл үүсгэсээр байна.

2020 оноос орон нутгийн хөрөнгө оруулалтаар театрын барилгын их засварт 298.5 сая төгрөг төсөвлөн баталж, Хөвсгөлбулаг ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулан 2020 онд 200.0 сая төгрөг, 2021 онд 98.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн ББКД-67-73/21 тоот дүгнэлт гарсан байна. Барилгын дээврийн 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажлаас Хөвсгөл аймгийн ИТХ-ын 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар 70.0 сая төгрөгийг батлан, гүйцэтгэгч Эндус эрхэт ХХК-д 2021 онд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Шинэ театрын барилгын газрыг данснаас хассан, 2020-2021 онд хуучин барилгад их засвар хийсэн, 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад “Хөгжимт драмын театрын барилгын 14-18 тэнхлэгийн шугаман суурийг хүчитгэх, шинэчлэх ажлын зураг төсөв”-ийн ажилд 10.8 сая төгрөг баталсан зэрэг хуучин барилгыг хүчитгэж засварлан, театрын зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах нь үр дүнд хүрэх эсэхэд анхаарал хандуулбал зохино гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын шилэн дансны мэдээллийг шалгахад 2021 онд 20.9 сая төгрөгийн орлогын 1, 85.3 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроосон, 6.6 сая төгрөгийн 1 мэдээлэл мэдээлээгүй, бусад мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 заалтад байгууллагын удирдлага нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллахаар заасан байтал тус театр өөрийн үйл ажиллагаанд нийцсэн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй байна.

БСШУС-ын 2015 оны А/495 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 5.3 заалтад заасны дагуу театрын сан хөмрөгт хадгалагдаж байгаа нот, клави́р, партитур, аудио, видео бичлэгийг каталогжуулан анхан шатны бүртгэлд оруулж, хөрөнгийн бүртгэлд тусгах заалтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийг тоглолтын хувцасны материал, хувцас, тайзны жижиг хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, техник, тоног төхөөрөмж гэх мэтээр төрөлжүүлэн ангилж бүртгээгүй байгаа нь бодлогын баримт бичгийг баталж, мөрдөх асуудалтай холбогдож байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд шалгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн асуудал холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, байгууллагын дансанд бүртгэлтэй байсан 500.0 сая төгрөгийн үнэлгээтэй газрыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолд үндэслэн данснаас хассан асуудлыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.1 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 27.1 сая төгрөгийн 6 алдааг залруулж, санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой 3 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 27.1 сая төгрөгийн 6 алдааг залруулсан. Үүнд:

1. Цалингийн тооцооллын алдаанаас илүү тооцоолж олгосон 0.6 сая төгрөгийг авлагад тооцож бүртгэсэн.
2. Үндсэн хөрөнгөнд 2.5 сая төгрөгийн ном бүртгэснийг бараа материалд шилжүүлж бүртгэсэн.
3. Үзвэрийн билетийг худалдан борлуулах үнээр үнэлж 4.6 сая төгрөгөөр орлогод авсан байсныг залруулан өртгөөр бүртгэсэн.
4. Бараа материалын тодруулгыг 8.8 сая төгрөгөөр алдаатай толилуулсан байсныг залруулсан.
5. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлуудыг алдаатай тайлагнасан байсныг залруулж 10.5 сая төгрөгийн зардлыг бараа материал акталсны зардлаар бүртгэсэн.
6. Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаарх танилцуулга бэлтгэж хавсаргаагүй байсныг аудитын явцад нэмж оруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Хөвсгөл аймгийн хөгжимт драмын театр нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана."-ыг мөрдөөгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: УСНББОУС-3 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөх

2. Үзвэрийн билетний тооцоотой холбоотой асуудал

- 2.1.1 Илрүүлэлт: Үзвэрийн билетний тооцоог тухай бүрт нь хийж хэвшээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг

зохион байгуулах, удирдах;" гэж заасныг мөрдөөгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 2.1.2 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх..." заалтын дагуу үзвэрийн билетний тооцоог хариуцсан ажилтантай тоглолт болсон тухай бүрт хийж баримтжуулж хэвших

3. Шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 3.1.1 **Илрүүлэлт:** Шилэн дансны цахим мэдээллийн системд 85.4 сая төгрөгийн орлогын 1, 20.9 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн орлогын 6.6 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтад "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь төсвийн ил тод байдал, "эрх ба үүрэг", "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 3.1.2 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын бүрэн хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр	9	27.1	6	27.1	-	-	-	-	3	-